



Говьсүмбэр аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬСҮМБЭР АЙМАГТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
БОДЛОГО ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

АУДИТЫН КОД: ГСА-2022/22-6-ШТА-ГА

Чойр хот 2022 он



Газрын дарга, тэргүүлэх аудитор **Б.Сарантуяа**

Утас: 7054-3156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер **Г.Наранбаяр**

Утас: 7054-3179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор **Б.Дарханбат**

Утас: 7054-3179 Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Аудитор **С.Батцэцэг**

Утас: 7054-3179 Цахим хаяг: battsetseg.sa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Б.Дарханбат Аудитор С.Батцэцэг 2022 оны 06 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг-1: Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 7 1.1. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд төлөөлөн удирдах зөвлөлгүй байна..... 7 1.2. Засгийн газрын 2016-2024, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн “төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах” бодлогын зорилт хэрэгжээгүй байна..... 8 Бүлэг-2: Орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагаа үр ашиггүй байна..... 11 2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зорилтот түвшинг хянаж батлаагүй байна. 11 2.2. “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна. 12 2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийдэггүй, зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй байна. 13 2.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааны үр ашиг муу байна. 14 Бүлэг-3: Орон нутгийн өмчит байгууллагуудын дотоод хяналт үр нөлөөгүй байна. 19 3.1. Орон нутгийн өмчит газруудын хөндлөнгийн хяналтаар илэрсэн зөрчил өмнөх оноос нэмэгдсэн байна..... 19 3.2. Орон нутгийн өмчит байгууллагуудын дотоод хяналт үр нөлөөгүй байна. 20 3.3. Орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна..... 21 Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар Хавсралтууд
---	--

Товчилсон үгийн тайлбар

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ДАХШҮХ	Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Аймгийн ИТХ болон засаг даргаас ОНӨААТҮГ, ОНӨҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол шийдвэр	8
2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт	8
3	Аймгийн Засаг даргаас ОНӨААТҮГ-уудтай байгуулсан гэрээ, гэрээг дүгнэсэн байдал	9
4	Эдийн засгийн зорилтот түвшин	11
5	2019-2021 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
6	Ус-Ду, Талын илч ОНӨААТҮГ-ын төлөгдөөгүй гааль, НӨАТ	12-13
7	Удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	14
8	Элэгдлийн зардлыг хассан ашгийн хэмжээ	16-17
9	Захирлуудад олгосон урамшууллын хэмжээ	17
10	Цалин сан, орон тооны төлөвлөгөө гүйцэтгэл	17
11	Ажиллагсад олгосон үр дүнгийн урамшуулал	17-18
12	ОНӨААТҮГ-т хийсэн хөрөнгө оруулалт	18
13	ОНӨААТҮГ-дын хөрөнгө оруулалтын төлөвлөлт	18-19
14	Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил	19
15	Өмч эзэмшлийн гэрээ дүгнэсэн байдал	19-20
16	СХДАА-ы хяналт шалгалтын үр дүн	20
17	ОНӨААТҮГ-уудын дотоод хяналтын төлөвлөгөөний гүйцэтгэл	20

Дүрслэлийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагааны чиглэл	7
2	Арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	7
3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	13

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Бодлогын баримт бичигт өгсөн үнэлгээ	26-28

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу хийлээ.
Аудитын зорилт	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах зорилт чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ➤ Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх ➤ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх ➤ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй цэвэр, бохир ус, дулаанаар хангагч 3 ОНӨААТҮГ болон “Цөм сүргийн үржлийн төв”, “Сум дундын ойн анги” ОНӨҮГ, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газрын 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны 69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ
Хүндрэл бэрхшээл	Аудитыг гүйцэтгэхэд орон тоо дутуу, бусад аудиттай аудитын хугацаа давхардсан зэрэг шалтгаанаар хүний нөөцийн дутагдал үүссэн нь аудитад хүндрэл учруулж байлаа.
Үндсэн мэдээлэл	Говьсүмбэр аймгийн хэмжээнд дулаан, халуун, хүйтэн болон цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах чиглэлээр үйл ажиллагаа

явуулдаг ОНӨААТҮГ-3, хог хаягдал, нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, хадгалалт хамгаалалтыг хариуцдаг-1, каракуль үүлдрийн хонины аж ахуй-1, мод үржүүлэг, ногоон байгууламжийг бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг-1 нийт 6 орон нутгийн өмчит газар үйл ажиллагаа явуулж байна.

Аудитад “Ус-Ду”, “Илчлэг шивээ”, “Талын илч” ОНӨААТҮГ, “Цөм сүрэг үржлийн төв”, “Сум дундын ойн анги” ОНӨҮГ гэсэн 5 байгууллагыг хамрууллаа.

Тус байгууллагууд нь 100% орон нутгийн өмчит бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлгүй, гүйцэтгэх удирдлагыг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлж байна.

2021 оны байдлаар 13,347.3 сая төгрөгийн хөрөнгөтэй, -156.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, улсын төсөвт төвлөрүүлэх орлого болон татаас санхүүжилт батлагдаагүй байна.

2019-2021 онд эдгээр байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой аймгийн ИТХ-ын 33 тогтоол, 14 захирамж шийдвэр гарсан байна.

Аймгийн ЗД-ын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудтай холбоотой 23 арга хэмжээ, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 5, эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 13, ТЭЗҮ боловсруулах шаардлагатай 8 арга хэмжээ тусгагджээ.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй байна уу?

Бүлэг 1

Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд төлөөлөн удирдах зөвлөл байгуулаагүй байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 6 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйл ажиллагааны чиглэлээр нь дүрслэлээр харуулбал:

Дүрслэл: №1



“Ус-Ду” ОНӨААТҮГ нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10-т заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл байгуулахаар компанийн дүрмийг шинэчлэн боловсруулж, аймгийн Засаг даргад танилцуулсан боловч аймгийн Засаг даргын 2021 оны А/626 тоот албан бичгээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хуулиар төлөөлөн удирдах зөвлөл байгуулах боломжгүй гэсэн хариуг хүргүүлжээ.

Тус газар нь Компанийн тухай хуульд заасан ОНӨҮГ-ыг компанийн хэлбэрт оруулсан байгууллага тул хуулийн дагуу төлөөлөн удирдах зөвлөл байгуулах боломжтой байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг тодорхойлж буй эрх зүйн баримт бичгүүдийн мэдээлэл зөрүүтэй, компанийн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал:

"Сум дундын ойн анги" ОНӨҮГ	"Талын илч" ОНӨААТҮГ	"Цөм сүрэг үржлийн төв" ОНӨҮГ	"Илчлэг Шивээ" ОНӨААТҮГ
Аймгийн ЗД-ын 2014 оны А/16 дугаар захирамжаар ОНӨҮГ хэлбэрээр байгуулсан боловч хуулийн этгээдийн бүртгэлд ОНӨААТҮГ-аар бүртгэлтэй.	- Дүрэм нь ОНӨҮГ боловч хуулийн этгээдийн бүртгэлд ОНӨААТҮГ-аар бүртгэлтэй 2004 оноос хойш дүрмийг шинэчлээгүй, удирдах зөвлөл ажиллуулах талаар тусгасан боловч хэрэгжээгүй.	- Аймгийн ИТХ-ын 2019 оны 20 дугаар тогтоолоор ОНӨҮГ болгон зохион байгуулалтын хэлбэрийг өөрчилсөн боловч хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт хийгээгүй - ОНӨААТҮГ нэрээр бүртгэлтэй, байгууллагын хэлбэр өөрчлөгдсөн боловч холбогдох өөрчлөлтийг тусгаж дүрмийг шинэчлээгүй.	Дүрмийг 1999 оноос хойш шинэчлээгүй, дүрэмд компанийн үйл ажиллагааны чиглэлийг тусгаагүй.

Энэ нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1¹, 16.2.6²-т заасныг зөрчсөн байна.

¹ 16.1.Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн.

² 16.2.6.компанийн үйл ажиллагааны чиглэл

1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн “төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах” бодлогын зорилт хэрэгжээгүй байна.

Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ болон ОНӨҮГ-ууд нь 100 хувь орон нутгийн өмчит бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлгүй тул Компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ-аас 2019-2021 онд орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын хөрөнгийн хөдлөлтэй холбоотой 30, үйл ажиллагаатай холбоотой 3, нийт 33 тогтоол, Засаг даргын 15 захирамж гарсан байна. Үүнээс компанийн засаглалтай холбоотой буюу зохион байгуулалтын хэлбэрийг өөрчилсөн 2 тогтоол гарчээ.

Аймгийн ИТХ болон Засаг даргаас ОНӨААТҮГ, ОНӨҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол шийдвэрийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

Тогтоол шийдвэрийн төрөл	Цалин хөлс тогтоох, тэтгэмж, урамшуулал олгох	Ажилд томилох, чөлөөлөх	Сахилгын арга хэмжээ авах			Дүн
Аймгийн ЗД захирамж	6	6	3			15
Аймгийн ИТХТ-ийн тогтоол	Бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх	Үйл ажиллагааг сайжруулах	Дүрэм батлах	Хөрөнгө барьцаалах	Хөрөнгийн бүртгэх, хасах, шилжүүлэх, худалдах	Дүн
	1	1	1	7	23	33

(Эх сурвалж: 2019-2021 онд гарсан аймгийн ИТХТ-ийн тогтоол, Засаг даргын захирамж)

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10 дахь заалтуудын хүрээнд аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг төлөвлөсөн байна.

Харин орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах чиглэлээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын зорилтыг Говьсүмбэр аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болон Барилга, хот байгуулалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгаагүй, арга хэмжээ төлөвлөөгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1.6³-д заасныг зөрчсөн байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ОНӨААТҮГ, ОНӨҮГ-уудын үйл ажиллагааг чадавхжуулахад чиглэж баталсан арга хэмжээний биелэлт, Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг аудитад хамрууллаа.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:
Хүснэгт №2

№	Баримт бичгийн нэр	ОНӨ-т газруудтай холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Аудитаар хэрэгжилтийн байдалд өгсөн үнэлгээ	АЗДТГ-ын ХШҮДАХ-ийн үнэлгээ
1.	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	12	75.0%	95.0%
2.	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	11	76.0%	87.0%
Нийт		23	75.5%	91.0%

³ Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээтэй уялдан байх;

(Эх сурвалж: АЗДТГ-ын ХШҮДАХ-ийн 2019-2021 онд мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, аудитын тулгалт)⁴

2016-2020, 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт ОНӨААТҮГ болон ОНӨҮГ-уудтай холбоотой 23 арга хэмжээ төлөвлөсөн боловч хэрэгжилт, үр дүн нь хангалтгүй, тайлагналын байдалд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээ нь тоон болон чанарын шалгуурт үндэслээгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү.) Тухайлбал:

- ❖ “Каракуль арьсны чиглэлийн Сүмбэр үүлдрийн хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөнө” гэсэн зорилт дэвшүүлж, хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг 3539 хонь байхаар баталсан. 2020 оны жилийн эцэст 1378 толгой хонь тоолуулсан байхад уг арга хэмжээг 100 хувь хэрэгжсэн гэж үнэлсэн.
- ❖ “Аймгийн төв, Шивээговь суманд цэвэрлэх байгууламж байгуулж, саарал усыг эргүүлэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн зорилт дэвшүүлж, хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг цэвэрлэх байгууламжийн тоо, хүчин чадал байхаар баталсан. 2016-2020 онд шинээр цэвэрлэх байгууламж байгуулаагүй байхад 100 хувь хэрэгжсэн гэж үнэлсэн.

Цаашид аймгийн ЗДТГ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, бодлогын баримт бичигт хийж буй ХШҮ-г шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэн зөв үнэлж, дүгнэх шаардлагатай байна.

Аймгийн Засаг даргаас ОНӨААТҮГ-уудтай байгуулсан гэрээ, гэрээг дүгнэсэн байдлыг харуулбал:


Хүснэгт №3

Баримт бичгийн нэр	Ус-Ду			Илчлэг шивээ			Талын илч			ЦСҮТ			СДОА		
	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
ГТ	х		1	х		1	х		1	х		1	х		1
ГТҮ	х		91.6%	х		91.8%	х		90.2%	х		80.3%	х		87.3%
ХАГэрээ	1	С	1	1	С	1	1	С	1	0	С	1	1	С	1
Хамтран ажиллах гэрээний үнэлгээ	91%	х	97.5%	0%	х	93.1%	90%	х	90%	0%	х	83%	87%	х	84.4%
ХШҮ-с өгсөн үнэлгээ	х		83.8%	х		84.5%	х		83%	х		64.3%	х		81.6%

(Эх сурвалж: АЗД-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ дүгнэсэн баримт 1-Гэрээ байгуулсан, С-Сунгалт, Х-хийгээгүй.)

Аймгийн Засаг даргаас Орон нутгийн өмчийн албатай байгуулсан гэрээгээр Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих зорилтын хүрээнд дараах арга хэмжээг төлөвлөж, тайлагнажээ.

Дүрслэл №3



(Эх сурвалж: АЗДТГ-ын ДАХШҮХ-ээс Орон нутгийн өмчийн албаны гэрээ дүгнэсэн баримт)

⁴ (Аймгийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээ, түүний хэрэгжилтийн байдалд өгсөн үнэлгээг хавсралт №1-т дэлгэрэнгүй харуулав.)

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь ОНӨААТҮГ болон ОНӨҮГ-уудын орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтад хяналт тавих чиг үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

- ❖ 2019-2021 онд Орон нутгийн өмчийн газраас ОНӨААТҮГ болон ОНӨҮГ-уудын “Өмч эзэмшүүлэх гэрээ”-ний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулсан.
- ❖ Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.
- ❖ Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн улсын үзлэг тооллого зохион байгуулсан.
- ❖ Аймгийн ИТХТ-ээс ОНӨААТҮГ, ОНӨҮГ-уудын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдон гарсан 2019 онд 6, 2020 онд 9, 2021 онд 13 тогтоолын хэрэгжилтийг хангуулж, 6,245.3 сая төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавьсан байна.

ОНӨААТҮГ болон ОНӨҮГ-т хүлээлгэн өгч буй хөрөнгө оруулалтын ажлын чанар, хадгалалт хамгаалалтын байдалд хийх явцын хяналт хангалтгүй байгаагаас зарим ажлууд үр дүнгүй болж орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зүйлд зарцуулагдах эрсдэлтэй байна. Тухайлбал:

- ❖ 2014-2016 онд Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 628.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Талын илч” ОНӨААТҮГ-т 2 ш уурын зуух, халаалтын шугам хоолойг хүлээлгэн өгсөн боловч ашиглагч байгууллага хэрэглээний зардал өндөр гарах, орон нутагт хүчин чадал нь хэт өндөр гэсэн шалтгаанаар үйл ажиллагаандаа ашиглаагүй, тухайн хөрөнгөд элэгдэл тооцоогүй байна. 2020 онд уг уурын зуухыг “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-т шилжүүлж тээвэрлэлт, суурилалтын зардалд 60.0 сая төгрөгийг зарцуулж, шилжүүлэн суурилуулсан боловч “Талын Илч” ОНӨААТҮГ-т хадгалалтын явцад элэгдэлд орж ашиглах боломжгүй болсон.
- ❖ 2020 онд Орон нутгийн төсвийн 147.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ус-Ду” ОНӨААТҮГ-т бохирын өргөх станцыг шинээр барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч 1 сарын дотор эвдэрч ашиглах боломжгүй болсон.
- ❖ 2020 онд Цөм сүргийн үржлийн төвд орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгөөр хонь худалдан авсан боловч малын тоо толгой өсөөгүй.

Цаашид ОНӨГ нь АИТХТ-ийн тогтоолын хэрэгжилтийг хангахаас гадна ОНӨААТҮГ, ОНӨҮГ-ын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад явцын хяналт хэрэгжүүлэх, орон нутгийн өмчийг зүй зохистой ашиглах, үр ашгийг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай байна уу?

Бүлэг 2

Орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагаа үр ашиггүй байна.

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зорилтот түвшинг хянаж батлаагүй байна.

“Ус-Ду”, “Талын илч”, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ууд нь 2019-2021 оны эдийн засгийн зорилтот түвшнийг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №4		(сая төгрөг)					
Он	Үзүүлэлт	“Ус-Ду” ОНӨААТҮГ		“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ		“Талын илч” ОНӨААТҮГ	
		Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Зорилтот түвшин	Гүйцэтгэл
2019	Орлого	1,694.1	1,662.5	407.4	392.8	302.22	347.86
	Зардал	2,365.5	1,912.3	665.3	577.1	438.04	408.37
	Ашиг алдагдал	-671.4	-249.8	-257.9	-184.3	-135.82	-60.50
2020	Орлого	1,384.6	1,443.5	413.1	425.1	302.22	354.10
	Зардал	2,138.5	1,799.3	674.6	558.6	428.66	396.96
	Ашиг алдагдал	-753.9	-355.8	-261.5	-133.5	-126.44	-42.85
2021	Орлого	1,830.7	2,305.4	560.4	549.9	302.75	381.14
	Зардал	2,493.8	2,360.3	987.3	726.7	419.15	354.07
	Ашиг алдагдал	-663.1	-54.8	-426.9	-176.8	-116.40	27.07

ОНӨААТҮГ-ууд зорилтот түвшинг алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн нь байгууллагын хүний нөөц, техникийн хүчин чадлаас хамаарч үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна нэмэлт орлого олох болон үнэ тарифыг жил бүр шинэчлэн тогтоох боломжгүй зэрэг нөхцөл байдал нөлөөлсөн байна. Тухайлбал:

- ❖ “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ халаалтын үнэ тарифыг 2014 оноос хойш шинэчлээгүй бөгөөд 2021 онд аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөр хянуулж, 2022 оноос мөрдөж эхэлсэн. Цэвэр усны үнэ тарифыг 2017 оноос хойш шинэчлээгүй бөгөөд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны тогтоолоор шинэчлэн батлуулж, 2022 оноос мөрдөж эхэлсэн.
- ❖ “Талын илч” ОНӨААТҮГ халаалтын үнэ тарифыг 2017 оноос хойш шинэчлээгүй бөгөөд 2021 онд аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөр хянуулж, 2022 оноос мөрдөж эхэлсэн.
- ❖ “Илчлэг шивээ”, “Талын илч” ОНӨААТҮГ-ууд нь техникийн болон хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж үндсэн үйл ажиллагаанаас өөр хэлбэрээр орлого бүрдүүлэх боломжгүй байна.

“Сум дундын ойн анги” болон “Цөм сүргийн үржлийн төв” нь ОНӨАТҮГ-ын статустай боловч байгууллагын үйлдвэрлэлийн болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулдаггүй, аймгийн СТСХ-т зөвхөн төсвийн төслийг бэлтгэн хүргүүлдэг, зарим ОНӨААТҮГ-ууд эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна. Тухайлбал:

- ❖ 2021 онд “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ нь зардлыг 2020 оны төлөвлөгөөнөөс 1.46 дахин нэмэгдүүлж, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхой бус байхад зардлыг 987.2 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Үүнд: Цалин, НДШ-ий зардлыг 243.2 сая, нүүрсний зардлыг 20.2 сая, сэлбэг засварын материалын зардлыг 40.4 сая, цахилгааны зардлыг 20.6 сая нийт 324.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ.

Мөн аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газраас ОНӨААТҮГ-уудын эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлтөийн байдал, тухайн жилийн бодлого чиглэлтэй нийцсэн эсэхэд урьдчилсан хяналт тавьдаггүй, хариуцсан мэргэжилтнүүдийн албан тушаалын чиг үүрэгт тусгаагүй байна.

Аймгийн Засаг даргаас 2019 онд “Ус-Ду”, “Талын илч”, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ, “Сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын захирлуудтай хамтран ажиллах гэрээг байгуулсан бөгөөд 2020 онд уг гэрээнд заасны дагуу гэрээний талууд өөрчлөгдөөгүй тул 1 жилийн хугацаатай сунгасан боловч эдийн засгийн зорилтот түвшнийг шинэчлэн батлаагүй байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2⁵, 20 дугаар зүйлийн 20.1.3⁶, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7⁷, “Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим⁸”-ыг зөрчсөн байна..

2.2. “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна.

ОНӨААТҮГ-ууд нь улс, орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлдэггүй бөгөөд үйл ажиллагааны орлогоос өөрийгөө санхүүжүүлэх чиг үүрэгтэй байна.

2019-2021 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5		(сая төгрөг)					
№	Байгууллагын нэр	2019		2020		2021	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Ус-Ду	1,694.1	1,662.5	1,384.6	1,443.5	1,830.7	2,305.4
2	Илчлэг шивээ	407.4	392.8	413.1	425.1	560.4	549.9
3	Талын илч	302.2	347.9	302.2	354.1	302.8	381.1
4	ЦСҮТ	95.3	85.1	144.2	133.9	130.0	125.4
5	СДОА	82.24	82.24	114.7	114.0	88.3	86.1
Нийт		2,581.2	2,570.5	2,358.9	2,470.6	2,912.2	3,448.0
Дундаж		99.6%		104.7%		118.4%	

Орлогын төлөвлөгөөг 99.6-118.4 хувиар биелүүлсэн бөгөөд “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2021 оны гүйцэтгэлд материаллаг хэмжээний өөрчлөлт оржээ.

“Ус-Ду” ОНӨААТҮГ-ын орлого 2021 онд төлөвлөсөн дүнгээс 474.7 сая буюу 25.9 хувиар давж биелсэн бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлого 216.6 сая, хөрөнгө оруулалтын ажлын /тендэрт оролцсон/ орлого 176.4 сая, бусад орлого 66.5 сая төгрөгөөр давсан байна. Орлого төлөвлөснөөс давж биелэхэд халаалтын улирлын хугацааг сунгасан, тусгай зөвшөөрлийн хүрээнд тендэрт оролцож хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэсэн, төлөвлөгдөөгүй орлого орсон нь нөлөөлжээ.

“Сум дундын ойн анги” ОНӨҮГ-т орлогын төлөвлөгөө батлагдаагүй, 100% төсвөөс санхүүжсэн бол “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь батлагдсан орлогын төлөвлөгөөг жил бүр биелүүлээгүйгээс төсвөөс авах санхүүжилтийг дутуу авсан байна.

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын худалдан борлуулах мах, арьсны үнийг аймгийн ИТХТ-дийн тогтоолоор баталсан, “Сум дундын ойн анги” ОНӨҮГ нь борлуулах суулгацын үнийг албан ёсоор тогтоогоогүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9⁹ -д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд “Цөм сүргийн үржлийн төв”, “Сум дундын ойн анги” ОНӨҮГ-ын борлуулалтын үнийг өртөгт үндэслэн тогтоох тухай зөвлөмж хүргүүлээ.

ОНӨААТҮГ-ууд Гаалийн татвар болон Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт бүрэн төлөхгүй байна.

⁵ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин

⁶ Зүйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

⁷ нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс

⁸ Орлого зардал уялдаатай байх зарчим

⁹ Улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох;

Хүснэгт №6	(Сая төгрөг)					
	2019		2020		2021	
Байгууллагын нэр	НӨАТ-гүй худалдан авсан бараа	Гааль, НӨАТ	НӨАТ-гүй худалдан авсан бараа	Гааль, НӨАТ	НӨАТ-гүй худалдан авсан бараа	Гааль, НӨАТ
“Ус-Ду”	59.2	8.9	44.4	6.7	-	-
“Талын илч”	36.1	5.4	26.8	2.6	26.0	3.9
Нийт дүн	95.4	14.3	44.4	6.7	26.0	3.9

(Эх сурвалж: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 онд ОНӨААТҮГ-уудын “Худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт”-эд хийсэн аудитын тайлан, СХАА-ны 2019, 2020 оны тайлан)

Ус, дулааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын ашигладаг уурын зуух БНХАУ-д үйлдвэрлэгдсэн бөгөөд зуухны засварын материалын олдоц муу, өртөг өндөр, барилгын материалын зах, худалдааны төвүүдэд НӨАТ болон төлбөрийн баримт олголт хангалтгүй, орон нутгийн хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалтад оролцоходоо материалын зардлыг багасгахын тулд БНХАУ-аас худалдан авалт хийж байна.

Энэ нь компанийн хувьд үр ашигтай боловч төсөвт төвлөрүүлэх орлого бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ 2017-2020 оны албан татвар ногдуулалт, төлөлтөд аймгийн Татварын хэлтсээс хийсэн хяналт шалгалтаар 5.9 сая төгрөгийн борлуулалтын орлого тайлагнаагүй, 176.4 сая төгрөгийг хуульд заасан хугацаанд төсөвт төлөөгүй зөрчил илэрч, 3.6 сая төгрөгийн нөхөн татвар, торгуулийг төлүүлсэн байна.

Уг асуудлаар өмнөх аудитаар зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийдэггүй, зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй байна.

ОНӨААТҮГ-уудын эдийн засагч, нягтлан бодогч нар үйл ажиллагаандаа үр ашгийн тооцоо, шинжилгээг тогтмол хийж үр нөлөөг нь үнэлж хэвшээгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан “удирдлагыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах” чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг даргатай 2019-2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээгээр ОНӨААТҮГ-уудын захирлуудад үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад чиглэсэн шууд худалдан авалт хийх 5.0-20.0 сая төгрөгийн эрхийг олгожээ. Тухайлбал: “Талын илч”, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ууд 2019, 2020 онд 5.0 сая хүртэл, “Ус-Ду” ОНӨААТҮГ 20.0 сая хүртэл, 2021 онд 20.0 сая хүртэл төгрөгийн эрхийг олгосон байна.

Босго үнээс давсан худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендер шалгаруулалт явуулах үүрэгтэй байна.

Мөн гэрээгээр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах үүргийг хүлээсэн байна.

2019-2021 оны ОНӨААТҮГ-ууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл:4



(Эх сурвалж: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ОНӨААТҮГ-уудын худалдан авах ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан)

Орон нутгийн өмчит компаниуд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг хангах үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- ❖ “Ус-Ду” ОНӨААТҮГ нь 2019 онд автомашин худалдан авах, 2020 онд өөрөө буулгагч ачааны автомашин худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөнд тусгаагүй.
- ❖ “Талын илч” ОНӨААТҮГ нь 2019 онд нүүрс худалдан авах, шатахуун тослох материал худалдан авах төсвийг тухайн жилийн үйл ажиллагааны зардалд төлөвлөсөн боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй
- ❖ 2019-2021 онд “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ, 2020 онд “Цөм сүргийн үржлийн төв”, “Сум дундын ойн анги” ОНӨҮГ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй.

ТЕЗ-ийн ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагүй, тендер шалгаруулалгүй шууд худалдан авсан нийт 886.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ❖ “Ус Ду” ОНӨААТҮГ нь 2019 онд нүүрсний зардалд 288.5 сая, шатахууны зардалд 55.0 сая, нийт 343.5 сая, 2021 онд засварын материал сэлбэг хэрэгсэл 501.3 сая (тендерийн ажилд оролцсон нь нөлөөлсөн)
- ❖ “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ нь 2020 онд урсгал засварын зардалд 13.4 сая, өвс тэжээл худалдан авах зардалд 14.0 сая, нийт 27.4 сая төгрөг
- ❖ “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ нь 2019 онд нүүрсний зардалд 102.2 мянга, шатахууны зардалд 18.4 сая, 2020 онд нүүрсний зардалд 147.2 сая, шатахууны зардалд 21.9 сая, 2021 онд нүүрсний зардалд 145.0 сая нийт 434.7 сая
- ❖ “Талын илч” ОНӨААТҮГ нь 2019 онд нүүрсний зардалд 50.0 сая, шатахууны зардалд 30.5 сая, нийт 80.5 сая төгрөг

Эдгээр алдаа зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлагыг өмнөх аудитаар өгсөн бөгөөд хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна. Тайлант хугацаанд Орон нутгийн өмчит газрууд нэгдмэл сонирхол бүхий этгээдтэй гэрээ байгуулаагүй байна.

Үүнээс гадна “Ус-Ду” ОНӨААТҮГ нь орон нутагт зарлагдаж буй хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтад оролцож, 530.2 сая төгрөгийн гэрээг байгуулан 98.0 сая төгрөгийн орлого олж компанийн үр ашгийг дээшлүүлж ажиллажээ.

2.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаан үр ашиг муутай байна.

Сум дундын ойн анги, Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ууд удирдлагын зардал төлөвлөөгүй бөгөөд “Ус-Ду”, “Талын илч”, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-уудын борлуулалт, удирдлагын зардлыг төлөвлөсөн байна.

ОНӨААТҮГ-уудын борлуулалт, удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт:7			(Сая төгрөг)
№	2019	2020	2021

Байгууллагын нэр	БУЗ төлөвлөгөө	Гүйцэтгэл	БУЗ төлөвлөгөө	Гүйцэтгэл	БУЗ төлөвлөгөө	Гүйцэтгэл
1 Ус-Ду	330.5	233.1	318.2	216.1	461.9	366.1
2 Илчлэг шивээ	200.5	129.8	0	0	174.1	148.4
3 Талын илч	137.0	134.4	132.0	134.7	136.0	120.8
Нийт	668.0	497.3	450.2	350.7	772.0	635.4
Дундаж	74.4%		77.9%		82.3%	

(Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын төлөвлөлтийн баримт)

Орон нутгийн өмчит газрууд Борлуулалт, удирдлагын зардлыг сүүлийн 3 жилд төлөвлөсөн хэмжээнээс 17.7-25.6 хувиар хэмнэжээ. Борлуулалт, удирдлагын зардлын дийлэнх хэсэг буюу дунджаар 79.0 хувийг цалин, НДШ, элэгдлийн зардал эзэлж байна.

“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ нь 2020 онд санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй, санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн баримтуудыг архивлаагүй байна.

ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон санхүүгийн тайлангийн аудитаар зардлын төлөвлөлт болон зарцуулалттай холбоотой дараах алдаа, зөрчлүүд илэрчээ. Үүнд:

Ус-Ду ОНӨААТҮГ:

1. 2019,2020 онд удирдлагын хэсэгт хуваарилагдах элэгдлийн зардлыг бодитой төлөвлөөгүй 2019-2020 онд тус бүр 82.0 сая, 2021 онд 57.9 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2019 онд 28.0 сая, 2020 онд 27.0 сая, 2021 онд 20.3 сая төгрөгийг тайлагнасан.
2. 2019 онд 3.2 сая төгрөгийг тэмцээн уралдаан, туршлага судлах, хоол буудлын зардалд 1.8 сая нийт 5.0 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 5.7 сая төгрөгийн удирдлагын зардлыг хуваарилсан. Жолоочийн замын хуудсанд спидометрийн заалт бичигдээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт 76.0 сая төгрөгийн түлш, шатахуун зарцуулсан.
3. 2021 онд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 14 ажилтанд 7.3 сая төгрөгийн урамшуулал олгосон. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 10.8 сая төгрөгийн удирдлагын зардалд хамаарах зардлыг бүртгэсэн. Аймгийн Засаг даргаар батлуулсан төлөвлөгөөнөөс цахилгаан, ус, холбоо, шатахууны зардлыг 26.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн.

Талын илч ОНӨААТҮГ:

1. Зардлын төлөвлөлтийг хийхдээ хэсэг тус бүрд гарах зардал, түүнээс орох орлогыг тооцоолдоггүй. 2019 онд дотоод томилолтын зардлыг тогтоосон хэмжээнээс 0.4 сая төгрөгөөр илүү олгосон, 26.7 сая төгрөгийн шатахуун, 0.6 сая төгрөгийн арга хэмжээ, 7.5 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын иж бүрдэлгүй зарцуулсан. 36.1 сая төгрөгийн бараа материалыг БНХАУ-аас худалдан авсан боловч гааль, НӨАТ-ыг төсөвт төвлөрүүлээгүй.
2. 2020 онд 19.2 сая төгрөгийн НӨАТ төлөөгүй худалдан авалт хийсэн, 25.6 сая төгрөгийн шатахууны зарцуулалтыг иж бүрдэл болоогүй анхан шатны баримтаар хийсэн. 1.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг нэхэмжлээгүй, 23.6 сая төгрөгийн борлуулалт удирдлагын хэсэгт ногдох элэгдлийн зардлыг төлөвлөөгүй, засварын зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс 21.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн.
3. 2021 онд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 3.7сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 0.5 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан. НӨАТ-гүй 26.0 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн.
4. 2014 оны Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн гадна инженерийн 5 хос шугам 169.6 сая, бохирын шугам 117.4, 1-р худгийн барилга 7.2 сая, худгийн агаарын шугам 26.4 нийт 320.6 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй байна.

Илчлэг шивээ ОНӨААТҮГ:

1. Зардлын төлөвлөлтийг хийхдээ хэсэг тус бүрд гарах зардал, түүнээс орох орлогыг тооцоолдоггүй. 2019 онд 25.9 сая, 2021 онд 8.3 сая төгрөгийг батлагдсан зардлын зүйл ангиас хэтрүүлж зарцуулсан. 2020 онд санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгээгүйгээс санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй.
2. 2018-2020 онд 8.3 сая төгрөгийн худалдан авсан хүнсний материалыг данс бүртгэлд тусгаагүй, 46.1 сая төгрөгийн шатахууныг иж бүрдэл болоогүй анхан шатны баримтад үндэслэн зарцуулсан. 1.2 сая

төгрөгийн ХХОАТ-ыг суутган төсөвт төвлөрүүлээгүй, айл өрхөөс авах 2.9 сая төгрөгийн авлагыг бүртгээгүй, 1.3 сая төгрөгийн албан томилолтын зардлыг хэтрүүлэн зарцуулсан, 19.6 сая төгрөгийн БНХАУ-аас бэлтгэсэн бараанд НӨАТ, Гаалийн татвар төлөөгүй, 1.9 сая төгрөгийн насосыг 3.2 сая төгрөгөөр орлогод бүртгэж зарлагдсан, 41.3 сая төгрөгийн бараа материалыг хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар худалдан авсан.

3. 2021 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалин хөлсийг 17.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан, авлагын бүртгэлд тавих хяналтгүйгээс 2.0 сая төгрөгийг тээврийн зардалд илүү төлсөн боловч авлагаар бүртгээгүй, нүүрсний зарцуулалтыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж 23.4 сая төгрөгийн зардал гаргасан, тээврийн хөлсөнд 6.8 сая төгрөгийн шатахуун олгосон гэх боловч гэрээ байгуулаагүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 24 ажилтанд 4.0 сая төгрөгийн урамшуулал олгож 1.0 сая төгрөгийн албан тасалгааны тавилга худалдан авсан.

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ:

1. 2019 онд 276 толгой мал хорогдсон, санхүүгийн тайланд 8.1 сая төгрөгийн авлага, 18.8 сая төгрөгийн өр төлбөр бүртгэсэн. Харилцах дансаар дамжуулалгүй 6.3 сая төгрөгийг бэлнээр зарцуулсан. Хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүй.

2. 2020 онд 21.0 сая төгрөгийн 109 толгой мал дутсан, нягтлан бодогч өөртөө 0.4 сая төгрөгийн цалин хөлс илүү тооцож авсан.

3. 2021 онд санхүүгийн тайланг илтэд алдаатай бэлтгэсэн, 7.6 сая төгрөгийн хурганы арьсыг бүртгээгүй, 26.5 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүй.

Сум дундын ойн анги ОНӨҮГ:

1. 2019 онд 0.2 сая, 2020 онд 0.2 сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан. 2019 онд 0.8 сая төгрөгийн бараа материалыг хүчин төгөлдөр бус баримт үндэслэн бүртгэсэн. 2.2 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримт бүрдэл хангаагүй баримтыг үндэслэж зарцуулсан.

Үүнээс үзэхэд орон нутгийн өмчит газруудын төлөвлөлт бодитой бус, зардлыг арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулаагүй байна.

2012 онд Эко сүмбэр хотхоны дулааны шугамыг төсвийн 220.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлж хүлээн авсан бөгөөд Орон нутгийн өмчийн албаны 2012 оны 77 дугаартай албан бичгээр “Ус-Ду” ОНӨААТҮГ-т бүртгүүлсэн. Уг шугамыг Илчит сансар ХХК ашиглан Эко сүмбэр хотхоныг дулаанаар хангадаг боловч “Ус-Ду” ОНӨААТҮГ-т 2021 оны жилийн эцсийн байдлаар 62.8 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцож, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингээжээ.

Аймагт үйл ажиллагаа явуулж буй Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа нь тогтворжоогүй, үр ашигтай ажиллах нөхцөл бүрдээгүй байна. Тухайлбал:

- ❖ Цөм сүргийн үржлийн төв, Сум дундын ойн анги нь үйлдвэрийн газар боловч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулдаггүй, түүнтэй холбоотой зардлын бүртгэлийг хөтөлдөггүй.
- ❖ Аймгийн ИТХ-аас бүтээгдэхүүний өртөг тодорхой бус байхад ЦСҮТ-ийн арьс, мах, маллагааны үнийг хатуу тогтоодог.
- ❖ Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй авлага, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авдаггүй.
- ❖ Хүний нөөц боловсон хүчин дутагдалтай, каракуль хонины чиглэлээр мал зүйч бэлтгэгдэхгүй болсон
- ❖ Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 5, эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 13, ТЭЗҮ боловсруулах шаардлагатай 8 арга хэмжээ тусгагдсан боловч Цөм сүргийн үржлийн төв, Сум дундын ойн анги ОНӨҮГ-т хөрөнгө оруулалтын арга хэмжээ төлөвлөөгүй, бодлогоор дэмжээгүй байна.

Цаашид аймгийн Засаг дарга нь Цөм сүргийн үржлийн төв, Сум дундын ойн анги ОНӨҮГ-ын одоогийн бүтэц зохион байгуулалтын хэлбэрт дүн шинжилгээ хийж, үр ашгийг дээшлүүлэх, ус дулаанаар хангагч байгууллагуудын техникийн хүчин чадлыг сайжруулах, үйл ажиллагаагаа үр ашигтай явуулах нөхцөл боломжоор хангахад анхаарах шаардлагатай байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын орон тоо болон урамшууллыг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтаар тогтоож байна. Тус гэрээгээр компанийн үйл ажиллагааны үр дүнгээс хамааруулж урамшуулах, захирлууд нь сар бүр инженер, техникийн ажилчдын ажлыг дүгнэж урамшуулах заалт орсон байна.

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын захирлын цалинг аймгийн Засаг даргын 2021 оны А/29 дүгээр захирамжаар ТҮ-9-3 ангиллаар тогтоосон байна. Тус байгууллагын удирдлага нь төрийн үйлчилгээний албан хаагчийн ангилалд хамаарахгүй бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8¹⁰-т заасны дагуу цалин хөлсийг гэрээгээр тогтоох зохицуулалттай байна.

Иймд Цөм үржлийн төв ОНӨҮГ-ын захирлын цалинг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу тогтоох зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

2019 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 9.7-д “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот төлөвлөгөөнд үндсэн хөрөнгийн элэгдлийг хасаж, бодитоор орсон орлого, зарцуулсан зардлаар тооцсон ашиг алдагдлын дүнгээр гэрээг дүгнэнэ” гэж заасан байна.

Элэгдлийн зардлыг хассан ашгийн хэмжээг сүүлийн 3 жилээр харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8			(Сая төгрөг)	
Байгууллагын нэр	2019	2020	2021	Дүн
Ус-Ду	220.3	125.7	440.2	786.2
Талын илч	11.1	28.1	71.7	111.0
Илчлэг шивээ	11.3	-	6.6	17.9
Нийт	242.8	153.8	518.5	915.1

(Эх сурвалж: ОНӨАТҮГ-ын санхүүгийн тайлан, төлөвлөлтийн баримт)

Гэрээнд заасны дагуу Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирлуудад аймгийн Засаг даргын 2019 оны А/278, 2021 оны А/397 тоот захирамжаар урамшуулал олгосон байна.

ОНӨГ-уудын захирлуудад олгосон урамшууллын сүүлийн 3 жилийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9			(Сая төгрөг)	
Байгууллагын нэр	2019	2020	2021	Дүн
Ус-Ду	4.36	-	1.28	5.64
Талын илч	3.82	-	1.02	4.83
Илчлэг шивээ	-	-	1.02	1.02
СДОА	0.71	-	0.96	1.67
ЦСҮТ	-	-	-	-
Нийт дүн	8.89	-	4.28	13.16

(Эх сурвалж: Орон нутгийн өмчит газруудаас авсан судалгаа)

2019 онд ажлын үр дүнгээр хангалттай үнэлгээ аваагүй “Илчлэг шивээ”, Цөм сүргийн үржлийн төв-ийн удирдлагуудад урамшуулал олгоогүй, 2020 онд аймгийн Засаг даргаас үйл ажиллагааны зорилтот түвшинг батлаагүй, гэрээний биелэлтэд үнэлгээ хийгээгүй тул урамшуулал олгоогүй байна.

Аймгийн Засаг даргаас орон нутгийн өмчит байгууллагын удирдлагуудтай байгуулсан гэрээний хавсралтаар бүтэц орон тоо, цалин санг тогтоосон байна.

Орон нутгийн өмчит байгууллагуудын цалин сан, орон тооны төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт №10			(Сая төгрөг)			
Байгууллага	2019		2020		2021	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл

¹⁰ 8/ цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулал;

“Ус-Ду” ОНӨААТҮГ:						
Орон тоо	62	51	61	57	61	58
Цалин сан	501.4	412.0	581.7	445.6	698.0	581.8
“Талын илч” ОНӨААТҮГ:						
Орон тоо	23	19	24	19	24	20
Цалин сан	138.5	138.1	138.5	136.7	138.5	134.5
“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ:						
Орон тоо	31	26	31	26	36	28
Цалин сан	234.4	165.4	214.9	203.6	423.6	184.7
“Сум дундын ойн анги” ОНӨҮГ:						
Орон тоо	6	6	6	6	6	6
Цалин сан	51.7	51.7	60.0	60.0	60.4	60.4
“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ:						
Орон тоо	11	11	11	11	11	11
Цалин сан	72.1	69.5	83.9	79.5	81.9	80.4

(Эх сурвалж: Орон нутгийн өмчит газруудаас авсан судалгаа)

Хүний нөөц хүрэлцээгүйгээс ус дулаанаар хангагч байгууллагууд бүрэн орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой цалингийн зардлын хэмнэлт үүссэн байна.

2019-2021 онд ажиллагсад олгосон үр дүнгийн урамшууллыг харуулбал:

Хүснэгт №11

(Сая төгрөг)

Байгууллагын нэр	2019	2020	2021	Дүн
“Ус-Ду” ОНӨААТҮГ	34.50	35.00	47.50	117.0
“Талын илч” ОНӨААТҮГ	8.10	3.40	3.70	15.2
“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ	4.89	3.11	3.90	11.9
“Сум дундын ойн анги” ОНӨҮГ	5.90	4.70	6.50	17.1
“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ	1.07	2.50	0.31	3.9
Нийт	54.46	48.71	61.91	165.1

(Эх сурвалж: Орон нутгийн өмчит газруудаас авсан судалгаа, анхан шатны баримт)

Газрын захирлууд аймгийн Засаг даргаас орон нутгийн өмчит байгууллагуудтай байгуулсан гэрээний хавсралтаар баталсан орон тоонд багтаан ажиллагсдын цалин хөлс, урамшууллыг тогтоож ирсэн байна. Ус, дулаанаар хангагч байгууллагууд хөдөлмөрийн дотоод журам болон хамтын гэрээнд заасны дагуу үр дүнгийн урамшууллыг олгосон бол Цөм сүргийн үржлийн төв болон Сум дундын ойн анги нь тухайн сарын ажлын гүйцэтгэлээс шалтгаалан хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажиллагсад ур чадварын нэмэгдэл олгожээ.

2019-2021 онд орон нутгийн өмчит байгууллагуудад нийт 4,333.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн байна.

Хүснэгт №12

(Сая төгрөг)

Шийдвэр	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Илчлэг шивээ	УсДу	ЦСҮТ	СДОА	Талын илч
АИТХТ-дийн 2019 оны 50-р тогтоол	Мод усалгааны нөөц сав	26.7	-	-	-	26.7	-
	Алсын худаг шилэн кабел хяналтын систем	9.0	-	9.0	-	-	-
	Худаг	25.7	-	-	-	25.7	-
	Бага оврын трактор	34.8	-	-	-	34.8	-
АИТХТ-дийн 2020 оны 25-р тогтоол	Хонь	20.0	-	-	20.0	-	-
	Бохир усны шугам-932м	300.0	-	300.0	-	-	-
АИТХТ-дийн 2020 оны 40-р тогтоол	Бага оврын ачааны автомашин	29.5	-	-	29.5	-	-
АИТХТ-дийн 2020 оны 79-р тогтоол	Худаг	29.6	-	-	-	29.6	-

АИТХТ-дийн 2020 оны 79-р тогтоол	Худаг	147.8	-	147.8	-	-	-
АИТХТ-дийн 2021 оны 46-р тогтоол	2-р баг тэрэгтийн өргөх станц, усан сан, худаг	3,424.3	-	3,424.3	-	-	-
	Орон сууцны барилгын шугам сүлжээ	92.1	-	92.1	-	-	-
	Зуухны засвар	54.2	-	54.2	-	-	-
	Зуух	139.8	-	-	-	-	139.8
Нийт		4,333.7	-	4,027.5	49.5	116.9	139.8

(Эх сурвалж: Аймгийн ИТХТ-ын тогтоол, аудитын ажлын баримт)

Орон нутгийн өмчит газрууд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөж ирсэн бөгөөд байгууллагын эдийн засгийн нөөц боломжоос давсан хөрөнгө оруулалтын ажлуудыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байна.

“Ус-Ду” ОНӨААТҮГ 2019-2021 онд, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ 2021 онд Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтаар шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гарган мөрдөж ажиллажээ.

Хүснэгт №13

(Сая төгрөг)

Санхүүжилтийн эх үүсвэр	2019	2020	2021
УТХО	700.0	200.0	200.0
ОНТХО		150.0	70.0
ОНХС	90.0	70.0	0
Өөрийн хөрөнгөөр	109.6	426.6	150.7
Эх үүсвэр шийдэгдээгүй	220.0		
	1,119.6	846.6	420.7

(Эх сурвалж: “Ус-Ду”, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын төлөвлөгөө, тайлан)

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй байна уу?

Бүлэг 3

Орон нутгийн өмчит байгууллагуудын дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.1. Орон нутгийн өмчит газруудын хөндлөнгийн хяналтаар илэрсэн зөрчил өмнөх оноос нэмэгдсэн байна.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж байна.

Мөн 2021 онд өөрсдийн санаачилгаар орон нутгийн өмчит газруудын 2019-2020 оны худалдан авах ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж 835.4 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илрүүлсэн. Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 835.4 сая төгрөгийн 5 зөвлөмж, 2 албан шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн өмчит газруудад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Хүснэгт №14

(сая төгрөг)

№	Байгууллагын нэр	Мөнгөн дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Залруулга
1	Ус-Ду	1,218.2		7.3	26.6	1,184.3
2	Илчлэг шивээ	154.5		95.2		59.3
3	Талын илч	1,118.9		251.8	867.1	-
4	СДОАнги	21.5		2.5		19.0
5	ЦСҮТөв	118.5	0.5	81.4	-	36.5
Нийт		2,631.5	0.5	438.3	893.7	1,299.1

Дээрх зөрчлөөс Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон цахим төлбөрийн Е-баримттай холбоотой зөрчил нийт зөрчлийн 60 хувийг эзэлж байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 209.1 сая төгрөгийн 43 алдаа зөрчил илэрч байсан бөгөөд алдаа зөрчлийн дүн 2022 онд 12.5 дахин нэмэгдсэн нь Шилэн дансны хуулийг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулж гүйцэтгэсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит байгууллагуудын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, өмч эзэмшлийн гэрээг дүгнэх чиг үүрэгтэй байна.

Орон нутгийн өмчит байгууллагууд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 9.1¹¹-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс эрх бүхий байгууллага гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгээгүй, 2020 оны эдийн засгийн зорилтот түвшинг батлаагүй байна.

Мөн сумдын Засаг дарга нар гэрээний 4.1-т¹² заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас Өмч эзэмшлийн гэрээ дүгнэсэн байдлыг харуулбал:

Хүснэгт №15

№	Аж ахуйн нэгжийн нэр	2019		2020		2021	
		Дүн хувиар	Үнэлгээ	Дүн хувиар	Үнэлгээ	Дүн хувиар	Үнэлгээ
1	"Ус-Ду" ОНӨААТҮГГазар	94	Сайн	95.7	Сайн	93.0	Сайн
2	Цөм сүрэг үржлийн төв	0	Хангалтгүй	67.8	Хангалтгүй	0	Хангалтгүй
3	Талын-Илч ОНӨААТҮГ	96	Сайн	92.8	Сайн	92.8	Сайн
4	Илчлэг-Шивээ ОНӨААТҮГ	0	Хангалтгүй	0	Үнэлүүлээгүй	92.8	Сайн
5	СДОАнги	94	Сайн	89	Хангалттай	96.0	Сайн

(Эх сурвалж: ОНӨГ-ын тайлан, мэдээ)

Аймгийн Татварын хэлтсээс 2021 онд “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2017-2020 оны албан татвар ногдуулалт төлөлтөд татварын хяналт шалгалт хийж, 3.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бөгөөд 100% төлөгдсөн байна.

3.2. Орон нутгийн өмчит байгууллагуудын дотоод хяналт үр нөлөөгүй байна.

“Ус-Ду”, “Талын илч”, “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ-ууд дотоод хяналтын журам боловсруулан баталж, дотоод хяналт хариуцсан ажилтныг томилсон бол Сум дундын ойн анги, Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ нь дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

“Илчлэг шивээ”, “Талын илч” ОНӨААТҮГ-ууд нь дотоод хяналтын төлөвлөгөө баталж, хяналтаар зөрчил арилгуулах зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжилтийг тухай бүр тооцдоггүй, жилийн эцэст хяналтын тайлан бичих хэлбэрээр хэрэгжүүлж байгаа нь дотоод хяналт үр нөлөөгүйг харуулж байна.

ОНӨААТҮГ-уудын дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт №17

№	Хуулийн этгээдийн Нэр	Хамрах хугацаа	Дотоод хяналтын нэгжийн мэдээлэл				
			Төлөвлөсөн хяналт шалгалтын тоо	Тайлагнасан хяналт шалгалтын тоо	Хяналтын үр нөлөө		
					Өгсөн зөвлөмжийн тоо	Хэрэгжсэн зөвлөмжийн тоо	Үр нөлөө
1	2	3	4	5	6	7	8

¹¹ Гэрээг жил бүр дүгнэх ба Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар гэрээний хэрэгжилт, хавсралтаар баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх төлөвлөгөөний биелэлтийг тус тус тухайн оны 02 дугаар сарын 25-ны дотор Орон нутгийн өмчийн албанд ирүүлнэ.

¹² Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагаа үр дүнг үнэлэхэд санал өгнө.

1	“УСДУ” ОНӨААТҮГ	2019 он	19	19	47	47	Хангалттай
		2020 он	17	17	43	43	Хангалттай
		2021 он	13	13	63	63	Хангалттай
2	“Талын илч” ОНӨААТҮГ	2019 он	17	17	0	0	Хангалтгүй
		2020 он	17	17	0	0	Хангалтгүй
		2021 он	0	0	0	0	Хангалтгүй
3	“Илчлэг ОНӨААТҮГ” Шивээ”	2019 он	39	31	0	0	Хангалтгүй
		2020 он	40	0	0	0	Хангалтгүй
		2021 он	35	18	0	0	Хангалтгүй

3.3. Орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2019 оны гэрээгээр тухайн жилийн гэрээний биелэлтийн тайланг 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн ЗДТГ-т хүргүүлж ажиллажээ.

Орон нутгийн өмчит байгууллагууд нь байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна. Тухайлбал:

- ❖ Орон нутгийн өмчит 5 байгууллагаас 4 нь цахим хуудасгүй.
- ❖ Үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд ил тод мэдээлээгүй.
- ❖ Шилэн дансны цахим хуудсыг тогтмол хөтлөөгүй.
- ❖ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаагүй.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 207.8 сая төгрөгийн 10 зөрчил илрүүлж зөрчлийг арилгах болон давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

1. Засгийн газрын төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах бодлогын зорилт Говьсүмбэр аймагт хэрэгжээгүй байна.

Бүлэг-2

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зорилтот түвшинг хянаж батлаагүй байна.
2. Зарим орон нутгийн өмчит үйлдвэрийн газар батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна.
3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийдэггүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.
4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа үр ашиг муутай байна.

Бүлэг-3

1. Орон нутгийн өмчит байгууллагуудын дотоод хяналт үр нөлөөгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

1. Цөм сүргийн үржлийн төв, Сум дундын ойн ангийн бүтэц зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж, үр ашигтай хэлбэрийг тодорхойлох

Аймгийн Засаг даргад:

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлогын зорилтыг аймаг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх
3. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн өмчит байгууллагуудтай холбоотой арга хэмжээг эрчимжүүлэх
4. Орон нутгийн өмчит газруудын санхүү, үйлдвэрлэлийн төлөвлөгөө, эдийн засгийн зорилтот түвшнийг жил бүр батлан үр дүнг тооцож ажиллах
5. Цөм үржлийн төв ОНӨҮГ-ын захирлын цалинг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу тогтоох

Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

1. Бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийхдээ зорилт түвшин, шалгуур үзүүлэлтийг үндэслэн бодитой үнэлэх, тодорхой зөвлөмжийг өгөх

Орон нутгийн өмчийн газарт:

1. Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх, Орон нутгийн төсвийн 147.8 сая төгрөгөөр хийгдсэн бохирын өргөх станцын ашиглалтын байдалд хяналт тавих

Орон нутгийн өмчит газруудад:

1. Баримт бичгийн зөрчлийг арилган, компанийн дүрмийг шинэчилж мөрдөх, Сум дундын ойн анги, Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ууд бүтээгдэхүүний өртгийг тооцож, өртөгтөө үндэслэн үнэ тогтоох
2. Орон нутгийн өмчит газруудын нягтлан бодогч, эдийн засагч нар санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ хийж, байгууллагын удирдлагыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх
3. Дотоод хяналт хариуцсан ажилтныг томилж, хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлах, хяналт шалгалтын үр дүнгээр зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажиллах, мэдээллийн ил тод байдлыг хангах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СУМ ДУНДЫН ОЙН АНГИ**
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр.
Утас: 7054 3500, И-мэйл: oip.angi3500@gmail.com

2022.07.01

№

47

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцсан санал
байхгүй болно.

ДАРГА



Т.ДАШЦЭДЭН

Аа В. Дархамбатаг
Саналыг тусган
тайланг батал-
гаа хүргүүлнэ
Ахуйс
2022

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМ
ИЛЧЛЭГ-ШИВЭЭ

АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Сэвхүүл, Шивээговь сум, Говьсүмбэр аймаг, 42030
Утас: 7054 6417, Цахим шуудан: ilchlegshiwee@yahoo.com

2022.07.01 № 103

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санхүүгийн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийг
хүлээн зөвшөөрч байна.

Цаашид зөвлөмжийн дагуу ажиллах болно.

ЗАХИРАЛ ИЛЧЛЭГ ШИВЭЭ Ш.ЧИНБОЛД
ГАЗАРТ



Ан Б.Доржамбааг
Саналыг тусламь
тайлаар батал-
гаажуулах

Анх
2022/07/01



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМ

ТАЛЫН ИЛЧ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

42043 Говьсүмбэр аймаг, Баянтал сум, 1 дүгээр баг,
Утас: 8883 0166, И-мэйл: taliinlich@yahoo.com

2022.06.30 № 56

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Манай 2019-2021 оны гүйцэтгэлийн аудитын
дүгнэлт, асуудлын бүртгэлд санал хүсэлт байхгүй
бөгөөд илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч байна.

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



[Signature]
А.БАТЖАРГАЛ

*А/а В.Дархамбааг
Саналыг хүлээн
тайлбар баталгаа
хуулах*
[Signature]

D:/Ажил/2022он/Тоом

70/

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЦӨМ СҮРЭГ ҮРЖЛИЙН ТӨВ

42017, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум

УБД: 3270327011 Утас: 70543074

2022.07.01 № 55
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус байгууллагын 2019-2021 оны үйл ажиллагааны үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэд өгөх саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ... хуудас

ЗАХИРАЛ



Г.БАТБАЯР

Анх Н. Дархаабаатар
Саналыг тусгаж
тайланг баталсан
хуучин

Анх Н. Дархаабаатар
2022.07.01

Цөм сүргийн үржлийн төвийн
2022 оны ᠒-д сарын ᠒-д өдрийн
Х.Х. тоотын ... дүгээр хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР

№	Алдаа, зөрчлийн товч утга	Санал	Тайлбар
1	Орон нутгийн өмчийн газар өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалтын байдалд анхаарч ажиллаагүй. Өмч эзэмшүүлэх гэрээгээр хангалтгүй үнэлэгдсэн, жил бүр малын тоо толгой буурсан.		Малын лентивирус нь 2016 онд анх манай аймагт бүртгэгдсэн. Түүнээс хойш судлагдаад явж байсан бөгөөд уг вируст каракуль хонь нь хэт мэдрэг байсан учраас 2019 оноос эхлэн бүрэн судалгаа хийгдсэн. Судалгааны дүнд уг вирус нь эмчлэгдэхгүй удаан хугацааны туршид агаар дуслаар халдварлагдан улмаар үхэлд хүрдэг болох нь нотлогдсон.
2	Борлуулах мах, арьсны төлбөрийг түүний өртөгт үндэслэн бодитоор тогтоогоогүй.	Борлуулах мах, арьсны тооцоо нь тухайн жилийн сүргийн эргэлтээр гардаг. Уг сүргийн эргэлтээр гарсан бүтээгдэхүүний борлуултын орлогыг төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлдэг боловч уг саналыг огт харгалзаж үзэхгүйгээр орлогын төлөвлөгөөг баталдаг.	Цөм сүргийн үржлийн төвийн 2019, 2020, 2021 онд хүргүүлсэн төсвийн хүрээний мэдэгдлийн тухай тухайн жилийн сүргийн эргэлтийн хуулбаруудыг хавсаргасан болно.



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
“УСДУ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

42010 Чойр, Говьсүмбэр аймаг, Утас. 7054-3270

2022. 07. 01 № 154

танай _____-ны № _____

Г

Г

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн
үйл ажиллагааны үр ашигт хийсэн гүйцэтгэлийн
аудитаар өгсөн зөвлөжид ямар нэгэн саналгүй
болно.

ЗАХИРАЛ



Б.ГАНЗОРИГ

Ага Б. Дорхонбаяр
Саналыг тусган
тайланг баталсан
нууц
Өмүс
24/01

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-аас ирүүлсэн саналтай танилцаад тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд бусад орон нутгийн өмчит газруудаас тайлангийн төсөлд өгөх санал ирүүлээгүй тул тайланг эцэслэн баталгаажуулав.

№	Байгууллагын нэр	Зорилт	АЗ-ын 2016-2020 оны ҮАХ-г хэрэгжүүлэх арга хэмжээ		Үнэлгээ	ХШҮДАХ	Тайлбар
1	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ, ЦСҮТ, СДОА ОНӨҮГ	Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ.	1.1	Төсвийн сахилга бат, санхүүгийн хяналтын үр дүнг сайжруулна.	70	100	Зорилт бүрэн хэрэгжээгүй буюу санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан байгууллагын тоо жилээс жилд буурсан.
2	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ, ЦСҮТ, СДОА ОНӨҮГ		1.2	Орон нутгийн хөгжлийн санг иргэдэд ил тод нээлттэй болгож, зарцуулалтын үр дүнг дээшлүүлнэ.	70	100	
3	ЦСҮТ ОНҮГ	Эрчимжсэн аж ахуйг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	6.16	Каракуль арьсны чиглэлийн "Сүмбэр" үүлдрийн хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөнө.	70	100	Шалгуур үзүүлэлтээр нь авч үзвэл зорилтот түвшинд хүрээгүй.
4	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ	Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна.	12.37	Аймгийн төв, Шивээговь суманд цэвэрлэх байгууламж байгууламж, саарал усыг эргүүлэн ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.	70	100	Шалгуур үзүүлэлтээр нь авч үзвэл зорилтот түвшинд хүрээгүй.
5	УС-ДУ ОНӨААТҮГ		12.39	Айл өрхүүдийг цэвэр бохирын шугам сүлжээнд үе шаттайгаар холбоно.	70	100	Зорилт бүрэн хэрэгжээгүй буюу 1-р багийн айл өрх цэвэр бохир усанд холбогдоогүй.
6	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ	Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.	13.47	Аймаг, сумдын төвийн усан хангамжийн эх үүсвэрт усны чанар сайжруулах, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулна.	70	100	Зорилт бүрэн хэрэгжээгүй буюу Шивээговь, Баянтал суманд халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулаагүй.
7	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ		13.48	Сумдын усан хангамжийн эх үүсвэрт өргөх станц, усан сан байгуулна.	70	100	Зорилт бүрэн хэрэгжээгүй буюу Баянтал, Шивээговь суманд өргөх станц, усан сан байгуулагдаагүй.
8	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ		13.49	Гэр хорооллын ус түгээх байрыг шинээр засварлан, ус түгээх автомашинаар хангана.	100	100	

9	УС-ДУ ОНӨААТҮГ		15.53	Аймгийн төвд дулааны станц барина.	40	40	
10	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ	Цахилгаан, дулааны эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангана.	15.54	Аймаг, сумдын дулаан хангамжийн зуухны хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	70	100	Зорилт бүрэн хэрэгжээгүй буюу Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-т 9.8 мВт хүчин чадалтай зуух ашиглалтад ороогүй.
11	СДОА	Ногоон бүс ойн зурвас байгуулан, газрыг хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна.	25.91	Аймаг сумдын төвд ногоон байгууламжийн бичил цэцэрлэг байгуулна	100	100	
12	СДОА		25.92	Ойн ангийн үйл ажиллагааг дэмжин, мод үржүүлгийн газрыг өргөтгөж, ойн зурвасыг хамгаална.	100	100	
Үнэлгээ					75	95	
№	Байгууллагын нэр	Зорилт	АЗ-ын 2020-2024 оны ҮАХ-г хэрэгжүүлэх арга хэмжээ		Үнэлгээ	ХШҮДАХ	
1	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ, ЦСҮТ, СДОА ОНӨҮГ	1.1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2	Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.	100	100	
2		1.1.2. “Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдал, хариу арга хэмжээг хангах арга хэмжээг зохион байгуулж, санхүүжилтийг шийдвэрлэнэ.	3	“Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана.	100	100	
3	ЦСҮТ	3.3.7 Каракуль хонины тоо толгойг өсгөж, аймгийн брэнд болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	19	Сүмбэр хонины тоо толгойг өсгөх, удмын санг хамгаалах, генетик нөөцийг зохистой ашиглах, бүртгэнэ.	66	66	
4			20	Сүмбэр үүлдрийн хурганы арьс бэлтгэх боловсруулах, эцсийн бүтэгдээхүүн үйлдвэрлэнэ.	63	63	
5	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ,	3.5.3. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим	5	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах шинэ техник технологи нэвтрүүлэх	50	100	Шалгуур үзүүлэлтээр нь авч үзвэл зорилтот түвшинд хүрээгүй дулааны тоолууртай болоогүй.

6		хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.	6	Эрчим хүч, ус дулааны үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.	100	100	
7	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ, ЦСҮТ, СДОА ОНӨҮГ	4.4.3. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ.	3	Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжинэ.	100	100	
8	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ	5.1.6. Төв суурин газрын ундны усны эх үүсвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.	6	Төв суурин газрын ундны усны эх үүсвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.	100	100	
9	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ	6.1.1. Сумдын инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1	Аймаг сумдын төвийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэнэ.	75	75	
10	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ	6.1.2. Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	2	Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбоно.	50	50	
11	Илчлэг шивээ, Талын илч, Ус-Ду ОНӨААТҮГ	6.1.3. Аймаг, сумдын төвд цэвэрлэх байгууламж барина.	3	Аймаг, сумдын төвд цэвэрлэх байгууламж барина.	30	100	Цэвэрлэх байгууламж барих ажил эхлээгүй.
Үнэлгээ					76	87	

